



Гэмт хэргийн талаар мэдээлэх арга

- **Гэмт хэргийг харсан юмуу хохирсон тохиолдолд 112 дугаарын утас руу мэдэгдсэнээр цагдаагийн тусламжийг хамгийн шуурхай авах боломжтой.**
 - Цагдаад мэдэгдэх үедээ хэзээ, хаана, яаж хохирсон ба гэмт хэрэгтн ий төрх, онцлог, авч явсан эд зүйл, тоо, зугтсан чиглэл болон тээврийн хэрэгсэл зэргийг тайван мэдэгдэх хэрэгтэй.
 - 112 дугаарын утас руу нийтийн таксоны яаралтай ярих товчлуур(улаан өнгийн яаралтай ярих товч+112)-ыг ашиглан ярих үед үнэ төлбөргүй ярих боломжтой ба гэмт хэрэг гараагүй байсан ч бусад яаралтай нөхцөлд ашиглах боломжтой.
 - ※ Гадаадын иргэн 112-д мэдээлэх тохиолдолд гурван талт хэлмэрч ийн үйлчилгээ (цагдаагийн ажилтан-хэлмэрч-нөхөмжлөгч) ашиглан гэмт хэргийн (хохирлын) дуудлагыг хүлээн авна.
 - Хэрэв та утсаар ярихад асуудал гарвал '112 яаралтай мэдээлэх аппли кэйш' ийг ашиглан мэдээлэл өгөх боломжтой.
 - ※ 112 яаралтай мэдээлэх аппликэйшнийг гар утаснаасаа Google Playstore болон Apple Appstore-оос татаж авч ашиглах боломжтой.
 - Баримт нотолгоог хадгалахын тулд цагдааг ирэх хүртэл эмх цэгцгүй болсон гэмт хэргийн газрыг тэр чигээр нь хөдөлгөлгүй орхих ба хэргийн газрыг шалгахад нь цагдаад дэмжлэг үзүүлэхийг хүсье.



Тусламж дуудах утасны дугаар

Гэмт хэргийг мэдэгдэх болон яаралтай утас	
Гэмт хэргийг мэдэгдэх (Цагдаагийн ерөнхий газар)	112
Сургуулийн хүчирхийллийг мэдээлэх төв (Цагдаагийн ерөнхий газар)	117
Гал түймэр, яаралтай тусламж үзүүлэх өвчтөн, яаралтай аврах ажиллагааны утас (Гал түймэртэй тэмцэх газар)	119
Хакер, спем, хувийн мэдээлэлд халдахад д мэдэгдэх(KISA)	118
Хэбараги төв (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1899-3075
Гэрээсээ төөрсөн хүүхэд, гэрээсээ оргосон хүнийг мэдэгдэх (Цагдаагийн ерөнхий газар)	182
Эмэгтэйчүүдэд туслах шуурхай зөвлөх утас (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1366
Данүри утасны төв (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1577-1366
Бусад өргөдөл хүсэлт	
Гадаадын иргэдэд зориулсан нэгдсэн мэдээллийн төв (Хууль зүйн яам)	1345
Засгийн газарт гаргах өргөдөл хүсэлтийн лавлах төв (Төрийн захиргаа ба аюулгүй байдлын яам)	110
Гадаад иргэдийн аялал жуулчлалын лавлах (Солонгосын аялал жуулчлалын газар)	1330
Хүний эрхэнд халдсан асуудлыг мэдээлэх, зөвлөгөө өгөх (Улсын хүний эрхийн үндэсний комисс)	1331
Хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ (Солонгос улсын хууль зүйн тусламжийн газар)	132
Хүүхэд хамгааллын газар (Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам)	129
Өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх зайны утас (Эмэгтэйчүүд, гэр бүлийн яам)	1388



Солонгосын цагдаа аюулгүй амьдрахад тань туслахад бэлэн байна.

Цагдаагийн газар нь Хууль зүйн яамтай хамтран гэмт хэргийн хохирогчийг аврах болон гадаад иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор 「Хууль бусаар оршин суугч иргэнийг холбогдох байгууллагад мэдэгдэх үүргийг шаардахгүй байх тогтолцоо」 г хэрэгжүүлж байна.

- 「Хууль бусаар оршин суугч иргэнийг холбогдох байгууллагад мэдэгдэх үүргийг шаардахгүй байх тогтолцоо」 нь хууль бусаар оршин суугч иргэн гэмт хэргийн хохиролын талаар цагдаад дуудлага өгсөн тохиолдолд тухайн гадаад иргэний хувийн мэдээллийг гадаад иргэн харьяатын албанд мэдээлэхгүй байх тогтолцоо юм.
- Үүнд дараах гэмт хэргүүд хамаарна.
 - (Эрүүгийн хууль) Хүний аминд хүрэх, бусдын биед гэмтэл учруулах, хүчирхийлэл, санаандгүй байдлаар хүний аминд хүрэх, хүч хэрэглэх, баривчилах, барьцаалах, сүрдүүлэх, хүний эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах, хүчирхийлэх, хүний биед халдах, заллан айлган сүрдүүлэх.
 - (Тусгай хууль) Хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдох ял шийтгэлийн тухай хууль, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэгт шийтгэл ногдуулах тухай тусгай хууль, зам тээврийн осол гэмтлийн талаархи тусгай хууль, биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль (46-р зүйл)

- Хэрэв та гэмт хэргийн хохирогч болсон бол эргэлзэлгүйгээр 112 утсанд залгаж тусламж авна уу.

Цагдаагийн газар очихгүйгээр хохирогчийн мэдээлэл ба иргэний хэргийг бүртгүүлэх боломжтой болгох зорилгоор гадаад иргэд байнга ирж очдог Олон соёлт гэр бүлд туслах төв, ТББ зэргийг “Гадаад иргэдэд туслах төв” болгон ажиллуулж байна.

Yйлчлүүлэх журам

1. Гадаадын иргэн гэмт хэргээс хохирол амсах юмуу хуультай холбоотой гомдол хохирол үүсэх
2. Гадаадын иргэдэд туслах төвд мэдэгдэх эсвэл зөвлөгөө авах
3. Гадаад иргэдийг хариуцсан цагдаад бүртгүүлэх
4. Цагдаагийн газар шийдвэрлэх юмуу холбогдох байгууллагад мэдэгдэх, шийдвэрлэх

- Гадаад иргэдэд туслах төв дээр ирж гэмт хэргийн талаар мэдээлэх эсвэл амьдрах явцад тохиолдсон бэрхшээлтэй зүйлүүдийн талаар зөвлөгөө авах хүсэлт гаргавал төвийн ажилтан үүнийг хүлээж аваад ойр байгаа цагдаагийн газрын хэрэг бүртгэлд дамжуулж, мэдээлсэн мэдээллийн дагуу цагдаагийн газрын ажилтан шууд шийдвэрлэх эсвэл холбогдох байгууллагад мэдээлнэ.



Гэмт хэргийг мэдээлэх ба зөвлөгөө өгөх, асуудлыг шийдэх хэлтэс

- Зорoon, гэр бүлийн хүчирхийлэл, сургуулийн орчинд үйлдэх хүчирхийлэл, хуурах(гомдол гаргах, мэдээлэх) зэрэг эрүүгийн хэргийн мэдээллийг цагдаагийн газрын зохих хэлтэсээс хариуцаж гүйцэтгэнэ.
- Цалингийн асуудал, үйлдвэрийн осол, оршин суух асуудал зэргийг Хөдөлмөрийн яам, Гэр бүлийн яам, Хууль зүйн яам зэрэг холбоо бүхий байгууллагад мэдэгдэх ба иргэний хэргийн агуулгаас хамаараад зохих эгчин сайдын яам, коноул руу мэдээлнэ.

- ※ Гадаад иргэдийн төвөөс ойрхон байгаа цагдаагийн газрын гадаад харилцааны алба руу холбогдон үйлчлүүлж болно.

Гэмт хэрэг (хохирол) ээс урьдчилан сэргийлэх болон жолооны эрх олгох сургалтанд хамрагдах боломжтой.

- Оршин сууж буй гадаад иргэдэд зориулж
 - Олон соёлт гэр бүлд туслах төв, ажлын байр, ТББ зэрэг гадаад иргэд ихээр цуглардаг газар очиж солонгос иргэнтэй гэр бүл болсон гадаад иргэд болон гадаад ажилчид, оюутнуудад байнга гардаг хэргийн талаар мэдээлэл олгож, анхаарах зүйлсийг нарийвчлан тайлбарлан, тулгарч буй бэрхшээлийн талаар зөвлөгөө өгөх 「Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт」-ыг явуулж байна.
 - Жолооны эрх олгох сургалтын шалгалтанд хамруулах зорилгоор мэргэжлийн багштай 「Гадаад иргэдийн жолооны эрх олгох курс」-ийг үнэ төлбөргүй явуулж байна.(Сурах бичгүүд 3 хэл дээр бий)

Жолооны сургалтын талаар лавлах

- **Зам тээврийн газрын жолооны эрхийн шалгалтын газар 1577-1120 (<https://www.safedriving.or.kr>)**
- **Жолооны дүрмийн шалгалт** 3 хэл дээр авах боломжтой Англи, Хятад, Вьетнам хэл

- ※ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт болон гадаад иргэдийн жолооны сургалтын талаар ойр байгаа газрын цагдаагийн газраас лавлаж, тусламж авч болно.

Солонгос хэл сайн мэдэхгүй гадаад иргэдэд зориулж хохирогчийн мэдээлэл өгөх ба иргэний хэргийн талаар зөвлөгөө өгөх үед орчуулгын үйлчилгээ үзүүлж байна.

Орчуулгын үйлчилгээ

- **Аялал жуулчлалын танилцуулга 1330**
 - солонгос, англи, япон, хятад 8 орны хэлээр
 - солонгос, англи, япон, хятад(24 цаг)
 - Орос, вьетнам, тайланд, малай хэл(08:00~19:00)
- **Данүри утас 1577-1366 (24 цаг)**
 - вьетнам, монгол, кымер зэрэг 13 орны хэлээр
- **Гадаадын иргэдэд зориулсан нэгдсэн мэдээллийн төв 1345, 1661-2025**
 - тайланд, индонез, үрд гм 20 хэлээр
 - солонгос, англи, хятад(09:00~22:00)
 - Вьетнам хэл зэрэг 17 хэл(09:00~18:00)
- **BVV корея 1588-5644 (24 цаг)**
 - турк, польш, хинди, малайз гм 20 хэлээр

www.police.go.kr

몽골어
Монгол хэл

Гадаад иргэдэд зориулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гарын авлага





Санамсаргүйгээр үйлдэж болох гэмт хэргийн төрөл

Хууль бусаар зураг авах, садар самуун зүйлийг түгээх дамжуулах зэрэг үйлдлүүд нь маш хатуу шийтгэлтэй.

■ Биед хүрээгүй ч гэсэн ① интернет болон гар утсаар бэлгийн ичгүүр төрүүлсэн үг, зураг илгээх, зураг илгээх ② зөвшөөрөлгүйгээр өөр хүний биеийн зураг авах, бичлэг хийх ③ зөвшөөрөлгүйгээр тараах нь гэмт хэрэг юм.

▶ Шийтгэх зүйл анги : ① Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тусгай хуулийн 13 дугаар зүйл (2 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл 5 сая хүртэлх хэмжээний воноор торгох) ②, ③ бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шийтгэх тусгай хуулийн 14 дүгээр зүйл (5 жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл 30 сая воноор торгох)

Мансууруулах бодис эзэмшсэн эсвэл хэрэглэсэн бол хатуу шийтгэл хүлээнэ.

■ Мансууруулах бодис зарах, худалдан авах, хүлээн авах, хууль бус аар хил давуулах эсвэл хар тамхи татах нь маш хүнд шийтгэлтэй.

▶ Шийтгэх зүйл анги : Хөнгөн гэмт хэргийг шийтгэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (10 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл 100 сая хүртэлх воны торгууль ногдуулах)

Хүч хэрэглэх, бусдын биед гэмтэл хөнөөл учруулах, айлган сүрдүүлэх, оршин суух газар руу халдах, эд хөрөнгийн хохирол учруулах, барьцаалах, албадах, заналхийлэх гэх мэт хэрэг үйлдэхийн тулд бүлэг байгуулах, бүлэгт нэгдэх, бүлэглэн үйлдсэн тохиолдолд маш хүнд ял шийтгэл авна.

Хутга, төмөр бороохой, төмөр хөрөө зэрэг хүний амь нас биенд хүнд гэмтэл учруулах мэсийг шалтгаангүйгээр биедээ авч явж болохгүй.

▶ Шийтгэх зүйл анги : Хөнгөн гэмт хэргийг шийтгэх тухай хуулийн 3 дугаар бүлгийн 2 дугаар зүйл (100,000 воноос доош хэмжээгээр торгох, цагдан хорих эсвэл торгох), Галт зэвсэг, хүйтэн зэвсэг, тэсрэх бодис зэргийг хураах тухай хуулийн 12 дугаар бүлэг (5 жилээс доош хугацаагаар хорих ял эсвэл 10,000,000 воноос доош хэмжээгээр торгох)

Мөрийтэй тоглох, мөрийтэй тоглоомын газар нээх

■ Мөнгө тавьж даалуу(хятад), хайлуу(тайланд), сугдиа(вьетнам), хөзөр, хуатү(солонгос хөзөр) зэргийг мөрийтэй тоглож болохгүй.
■ Мөрийтэй тоглох газар байраар хангасан тохиолдолд ч бас мөрийтэй тоглоомын үйлдлийн жишгээр хатуу шийтгэл онооно.

Замын хажууд тавьсан дугуй зэргийн эзэнгүй мэт харагдсан эд зүйл байлаа ч дур мэдэн авч явсан тохиолдолд хулгай эсвэл алдсан эд зүйлийг шамшигдуулсан гэмт хэрэгт багтана.

Банкаар дамжуулалгүйгээр хувь хүмүүсийн хоорондын арилжаагаар гадаад руу мөнгө гуйвуулах үйлдэлд хатуу шийтгэл онооно.

17-оос дээш насны гадаадын иргэн гадуур явахдаа гадаад иргэний үнэмлэх болон гадаад паспортоо байнга биедээ авч явах шаардлагатай бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд (1 сая вон хүртэл) торгууль ноогдуулна.

■ Хэрэв өөр хүний биеийн байцаалт болон хуурамчаар үйлдсэн бичиг баримт ашиглах тохиолдолд хуурах зорилгоор албан үүрэг гүйцэтгэхэд саад болсон гэж үзэн шийтгэл ноогдуулна.

※ Цагдаагийн ерөнхий газар ба Хууль зүйн яам(Хилийн шалган нэвтрүүлэх бодлогын газар) нь 2014 оноос эхлэн гадаад иргэний талаарх мэдээлэл дээр хамтран ажиллаж байна

Жолооны үнэмлэхгүйгээр машин болон мотоцикл жолоодох зэрэг дараах тохиолдолд хүнд шийтгэл авна.

■ Жолооны үнэмлэхгүй жолоо барих тохиолдол

▶ Шийтгэх зүйл анги : ① Машин → 1 жил хүртэлх хугацаагаар хорих, 3 сая хүртэлх воноор торгох ② Мотоцикл → 300,000 хүртэлх воноор торгох

■ Согтуу жолоо барих тохиолдол

Цусан дахь архины концентраци	Хүлээлгэх хуулийн хариуцлага	Захиргааны шийтгэл
0.03% ~ 0.08% (0.03% буюу түүнээс дээш 0.08% -иас бага)	1 жил хүртэлх хугацаагаар хорих ял	Жолооны эрх хасах
0.08% ~ 0.2% (0.08% буюу түүнээс дээш 0.2% -иас бага)	1-2 жилийн хорих ял	Жолооны эрхийг хүчингүй болгох
0.2% ба түүнээс дээш	2-5 жилийн хорих ял	Жолооны эрхийг хүчингүй болгох
2-аас дээш удаа согтуугаар жолоо барьсан тохиолдол	2,5 жилийн хорих ял	Жолооны эрхийг хүчингүй болгох

■ Албан ёсоор зээмшигчийн нэрийг солиулаагүй (өөр хүний зээмшилтэй машин) барих тохиолдолд

▶ Шийтгэх зүйл анги : Автомашинч хянан зохицуулалтын тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 7-2 дахь хэсэг (1 жил хүртэлх хугацаагаар хорих эсвэл 10 сая хүртэлх воны торгууль ногдуулах)

Үндсэн ёс журам сахиулах дүрэм зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах тул анхаарч болгоомж хэрэгтэй.

■ Тамхины иш хаях, бохь, хог зэргийг хамаагүй хаяж болохгүй
■ Олон нийтийн газар шүлсээ хамаагүй хаях, тамхи татахыг хориглоон газарт тамхи татаж болохгүй.
■ Мотоцикл барьж байгаа болон хамт сундалж яваа хүн хамгаалалтын малгай өмсөх ба зам хөндлөн гарахдаа гүүр болон явган хүний замаар гатална.



Өдөр тутмын амьдралын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах арга

Залилан (Хууль бус сүлжээ худалдаа, утсаар санхүүгийн залилан хийх<Voice Phishing> цахим залилан гм)

■ Уламжлалт бөөний ба жижигтэнгийн худалдааны дамжлагаар биш үйлчилгэгч шууд худалдаалагч болж бүтээгдэхүүн зарах, дараах тохиолдолд гишүүнээр элсэх буюу худалдагч болохоос татгалзах хэрэгтэй.

• Богино хугацаанд өндөр ашиг олох боломжтой гэж хууран гишүүн, хөрөнгө оруулагч цуглуулан их хэмжээгээр бүтээгдэхүүн зарах, хүчээр тулган зарах, зээл авахуулах зэргийг санал болгох
• Цагийн ажил, гэрээсээ ажиллах боломжтой хэмээн ажлын байр олгох нэрийдлээр худалдагчаар бүртгэх, бодитоор бол хүчээр бүтээгдэхүүн худалдаалах
• Бүтээгдэхүүнийг өндөр чанартай болгон хуурамчаар, хэтрүүлэн сурталчлах, өндөр үнээр зарах тохиолдолд татгалзаж байх хэрэгтэй.



Албан ёсны бүртгэлтэй сүлжээний бизнес эсэхийг шалгаж нягтлах

- Шударга худалдааны хороо www.ftc.go.kr, 044-200-4010
- Шууд худалдааны харилцан туслах нийгэмлэг www.macco.or.kr, 02-566-1202
- Солонгосын онцгой худалдааны харилцан туслах нийгэмлэг www.kossa.or.kr, 02-2058-0831

■ Олон нийтийн байгууллага юмуу санхүүгийн байгууллагын нэрийг эзэлдэн данс, карт, иргэний үнэмлэх зэрэг хувийн мэдээлэл юмуу бэлэн мөнгө шилжүүлэхийг шаардах зэргээр утсаар мөнгө залилах гэж буй мэт сэжиг төрсөн тохиолдолд зайлшгүй холбогдох байгууллагаас асууж тодруулах шаардлагатай.

※ Залилангийн бүлэглэлийнхэн бэлэн мөнгө гарган авагч болон лавлах төвийн телемаркетинг болж бусадтай ярих нь залилангийн хэрэгт хамаарч хүнд шийтгэл оногддог.



Voice Phishing-ийн жишээ

- Танай хүүхдийг утсаа авахгүй байгааг далимдуулан хүүхдийг чинь барьцаалсан хэмээн мөнгө нэхэх
- Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалын газрын нэрийг ашиглан татвар төлүүлэхээр мөнгө нэхэх
- Банк, карт, холбооны газрын нэрийг ашиглан картны мөнгө болон үйлчилгээний хөлсөө төлөхгүй хугацаа хэтрүүлсэн хэмээн мөнгө төлөхийг шаардах,
- Цагдаа, прокурор зэрэг мөрдөн байцаах газрын нэрийг барин хувийн мэдээлэл болон санхүүгийн мэдээллээ өгөхийг шаардах
- Майлээр найз чинь өөрийнхөө данс руу биш өөр данс руу мөнгө шилжүүлж өгөхийг шаардах

■ Интернетээр дамжуулан хувь хүмүүс хоорондоо шууд гүйлгээ хийхгүй байх, интернет худалдааны төв ашиглахдаа бизнесийн мэдээллийг сайтар шалгаж үзэх хэрэгтэй.

※ Сайбер аюулгүй байдлын хэлтэс(cyberbureau.police.go.kr) болон сайбер каб(mobaill app) : интернет гэмт хэргийн сэжигтэнгийн талаар мэдээлэх харах ба хохирлын тухай мэдээлэх

Гэр бүлийн хүчирхийлэл, болзооны үеийн хүчирхийлэл

■ Гэр бүлийн хүчирхийлэл-Болзооны үеийн хүчирхийлэлд өртсөн бол ичиг зоволгүйгээр цагдаа болон хамаатан садан, хөршүүд, найз нөхөддөө мэдэгдэж тусламж хүснэ үү.

※ Зураг, магадлагаа зэрэг хүчирхийллийн талаарх нотлох баримтыг баталгаажуулан эмэгтэйчүүдийн байгууллага болон хамгаалах байр зэрэг гэр бүлийн хүчирхийллийн мэргэжлийн зөвлөгөө өгөх байгууллагаас зөвлөгөө авах (Эмэгтэйчүүдэд туслах шуурхай зөвлөх утас 1366 / Да нүри дуудлагын төв 1577- 1366)

■ Гэр бүлийн хүчирхийлэл / Болзооны үеийн хүчирхийлэл гарах магадлалтай үед өөрийн(хүүхдийн гэх мэт) аюулгүй байх нь хамгийн лахуч тул тухайн газрыг түр орхиж аюулд өртөхөөс сэргийлэх хэрэгтэй.

Хүүхэд ор сураггүй алга болох, хүн хулгайлах, дарамтлахаас сэргийлэх

■ Хүүхдэд хэн нэгэн танихгүй хүн сайн таньдаг дүр эсгэх мөн хүчээр авч явах гэвэл чанга хашигирч эргэн тойрноосоо тусламж хүсэх хэрэгтэй гэж зааж сургана.

■ Хүүхдэдээ нэр, нас, хаяг, утасны дугаар, эцэг эхийн нэр зэргийг сайтар мэддэг болгож, хүүхэд гадагш гарах үед хэнтэй хаашаа явах ямар хувцас өмсөж явсныг нь анхаарах хэрэгтэй.

■ Хүүхэд гадагш гарахад утасны дугаар бүхий зүүлт, бугуйвч, нэрийг нь бичсэн зүүлтийг хүний нүдэнд амархан өртөхөөргүй газар зүүлгэнэ.

■ Хүүхдийн хүчирхийлэл бол биеийн, бэлгийн, сэтгэл зүйн хувьд дарамтлах, хүүхдээ асрахгүйгээр орших тохиолдолд хүнд шийтгэл оногдуулна.

Сургуулийн хүчирхийлэл

■ Сургуулийн орчинд хүчирхийлэх гэдэг нь сургууль дотор сурагчийг зодох, айлган сүрдүүлэх, гадуурхах гм биеийн болон сэтгэл зүйн хувьд мөн эд хөрөнгийн хохирол учруулахыг хэлнэ

■ Хүн ховор явдаг гудамж зэргээр ганцаараа явахгүй байх ба хэрвээ танхай этгээдэд мөнгөө алдсан бол цагдаад мэдээлэх зэрэг зохих арга хэмжээг авна.

■ Хохирол амссан тохиолдолд хохироогчийн талаарх мэдээлэл болон хэзээ, хаана, яаж хүчирхийлүүлсэн талаарх баталгаа ба хэргийг нүдээрээ харсан найз нарын гэрчлэл байвал сайн.

Бэлгийн гэмт хэрэг (Хүчин, бэлгийн дарамт, хууль бусаар зураг авч бичлэг хийх, биеэ үнэлэлт гэх мэт)

■ Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд усанд орохгүйгээр өмсөж буй дотуур хувцас болон гадуур хувцасаа өмссөн хэвээр 112 дугаарт дуудлага өгнө үү.

■ Гэмт этгээдийн онцлог болон гадаад төрх мөн тухайн үеийн байдалын талаар санаж буй бүх зүйлээ бичиж авна уу

■ Эргэн тойронд чинь бэлгийн дарамтанд өртсөн хүн байгаа бол түүнийг сонсож 112 болон 1366 дугаар руу холбогдон зөвлөгөө авхуулах арга хэмжээ авна уу.

■ Хэрэв та албадан бэлгийн мөжлөг, биеэ үнэлэх дарамтад орох зэрэг хохирол амссан бол 1577-1366 руу залгаж зөвлөгөө аваарай.

Утсаар бусдын мөнгө залилан луйвардах(смишин, Smishing)

■ Гар утасны мессежээр 'үнэгүйгээр купон өгөх' зэрэг агуулга бүхий мессеж дамжуулсаны дараа интернетийн хаягыг дарж ормогц → вирус smart утсанд сууж → хохирогчийн зөвшөөрөлгүйгээр тооцоо хийгдэх мөн хувийн болон санхүүгийн мэдээлэл алдагдана

■ Ойрын хүмүүсээс чинь ирсэн мессеж ч гэлээ интернет хаяг хамт ирвэл дарж орохоосоо өмнө утасдаж лавлах шаардлагатай ба smart утсанд янз бүрийн апп суулгахаас зайлсхийж хамгаалах хэрэгтэй

※ smart утсыг хамгаалах арга : сеттинг → хамгаалалт → дибайс → 'эх сурвалж мэдэгдэхгүй' гэдэгт V тэмдэглэгээ хийнэ.

Хулгай (айл ухах, халаас суйлах, шүүрэх гэх мэт)

■ Удаан хугацаагаар гадагш явах юмуу амралт зэргээр урт хугацаагаар гэр зэгүй байх тохиолдолд

• Сонин юмуу сүү зэрэг байнга хүргэгдэн ирдэг зүйлийг гэрийн урд бөөгнөрч хураагдахгүй байхаар урьдчилан зохицуулахын хажуугаар сүү оруулах нүх зэргийг зайлшгүй хааж түгжинэ.

• Үнэт эдлэл юмуу бэлэн мөнгө зэрэг үнэтэй зүйлсээ банкинд хадгалуулж, гэртээ хадгалах тохиолдолд энд тэнд тохиромжтой газар тарааж хадгалах нь найдвартай.

■ Хүн их цуглардаг терминал, зах зэрэг их хөлийн газар анхаарал сулрахыг далимдуулан эд зүйлс авч зугатах асуудал гардаг тул анхааралтай байх хэрэгтэй.

■ Гоёлын цүнх юмуу үүрдэг цүнхээ зам талдаа барихгүй байж, ямагт хана тал руугаа харуулан барих ба аль болох цүнхний оосрын уртыг хэтэрхий урт бишээр тохируулан мөрнөөсөө цээж рүүгээ диагональ хэлбэрээр зөрүүлэн үүрэх хэрэгтэй.

■ Банк санхүүгийн байгууллагаас их хэмжээний бэлэн мөнгө авах тохиолдолд гэрээт цагдаа юмуу цагдаагийн ажилтнаас аль болох тусламж хүсэх хэрэгтэй.